



**ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/36.

Зуунмод


**Журам баталж мөрдүүлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.5, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод-Улаанбаатар, Улаанбаатар-Зуунмод хот хооронд нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр хөнгөлөлттэй нөхцөлөөр Зуунмод сумын өндөр настан, тусгай хэрэгцээт иргэн, оюутан сурагчдад үйлчлэх журмыг хавсралтаар баталж 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.САРАНГЭРЭЛ